



**Аж үйлдвэрийн төлөвлөлт болон
нээлттэй бүсийн бүтээн байгуулалт**

CHEN JIAN XUN cjx888@sass.org.cn

**Шанхай хотын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн
аж үйлдвэрийн хөгжлийн судалгааны төв**

Нэг. Аж үйлдвэрийн төлөвлөлтийн тухай үзэл баримтлал

- ❖ Үндсэн үзэл баримтлалтай болж байж бодлогын хувьд, нэгэн цогц үйл ажиллагааны зорилготой болно. Зөв оновчтой үзэл баримтлал нь тухайн байгууллагын үйл ажиллагааг дээшлүүлнэ.
- ❖ Үзэл баримтлал гэж юу вэ? Энэ нь ирээдүйн стратегийн зорилтуудаа тодорхойлох тодорхойлолт юм. Стратегийн зорилтуудаа тодорхойлсоны дараа нэгэн цогц бодлогыг боловсруулах явдал юм. Үүнд аж үйлдвэрийн бодлого багтана. Стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд нэгдсэн нэг аргыг хэрэгжүүлэх ёстой. Аливаа бүс нутгийн үзэл баримтлал нь эдийн засаг, нийгэм, соёлд тулгуурласан нийлмэл цогц бодлого байх бөгөөд тухайн байгууллагын ажлын үндэс суурь болох ёстой.

Хоёр. Аж үйлдвэрийн төлөвлөлтийн агуулгын тухай

- ❖ **Аж үйлдвэрийн салбар нь Үндсэн гол үйлдвэр, тулгуур үйлдвэр, туслах салбар дэмжих үйлдвэр гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдүүлдэг**
- ❖ Үндсэн гол үйлдвэр - гэдэг нь байгалийн баялагт тулгуурласан, тухайн бүс нутгийн үйлдвэрийн хөгжлийн түвшинг илэрхийлэх хэмжээний, бүс нутгийн аж үйлдвэрийн салбарын тэргүүлэх үйлдвэр бөгөөд ийм үйлдвэр нь томоохон хэмжээний цар хүрээтэй байдаг. Жишээлбэл, Иракийн газрын тосны аж үйлдвэр.
- ❖ Тулгуур үйлдвэр - гэдэг нь тухайн бүс нутагт томоохон хэмжээний үйлдвэр бөгөөд, орон нутгийнхаа эдийн засагт ихээхэн хувь нэмэр оруулдаг аж үйлдвэрийг хэлнэ.
- ❖ Туслах салбар - гэдэг нь үндсэн үйлдвэр болон тулгуур үйлдвэрийг дэмжих үйлчилгээ үзүүлдэг салбарыг хэлнэ. Жишээлбэл, ложистик, санхүүгийн үйлчилгээ гэх мэт тухайн үйлдвэрийг дэмжих салбарууд багтана.
- ❖ Дэмжих үйлдвэр - гэдэг нь үндсэн үйлдвэр, тулгуур үйлдвэрийн нэг хэсэг болж үйлдвэрлэлийн тодорхой нэг хэсгийг боловсруулдаг үйлдвэр юм. Жишээлбэл, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний анхан шатны боловсруулалт хийдэг үйлдвэр нь уг ангилалд хамаарна.

Гурав. Хөгжлийн бүсийн төлөвлөлт болон бүтээн байгуулалт (Нэг)

❖ **Ерөнхий төлөвлөлтийн агуулга:**

❖ Эдийн засгийн хөгжлийн гол зүйл нь төлөвлөлт юм.

❖ Төлөвлөлт нь аж үйлдвэрийн төлөвлөлт, аж үйлдвэрийн хөгжлийн чиг баримжаа, аж үйлдвэрийн тогтолцоо, бүтэц, хэлхээ холбоо, орон зайн зохион байгуулалт, дэд бүтцийн төлөвлөлт, нийгмийн асуудал, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ, эцэст нь төсөл хэрэгжүүлэх үйл явц багтана.

❖ **Бодит агуулга**

1. Аж үйлдвэрийн бүсийн хөгжлийн стратегийн хандлага : Юуг төвөө болгон ажиллах, юугаар хөгжлийн хөдөлгүүр хийх, юуг зорилтоо болгон ажиллах бэ

2. Нөөцийг нэгтгэх төлөвлөлт: Нийгмийн хөрөнгө, аж үйлдвэрийн хөрөнгө, нөөцийн (газар, нүүрс, газар тариалан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн гэх мэт), санхүүжилтын хөрөнгийг ашиглан хэрхэн дээрхи дөрвөн зүйлийн холбоо хамаарлын гурван хэмжээст загвараар хэрхэн ашиглах талаар.

3. Аж үйлдвэрийн стратегийн төлөвлөлт: Тухайн үйлдвэр нь эрэлт нийлүүлэлтийн дагуу зах зээлд хэрэгцээтэй бараа материал үйлдвэрлэх ёстой. Үйлдвэр хөгжихөд тухайн газар нутагт байгаа ажиллах хүчин, нөөц баялаг шинэ технологи, хөгжил дэвшил нөлөөлнө.

Гурав. Хөгжлийн бүсийн төлөвлөлт болон бүтээн байгуулалт (Хоёр)

4. Аж үйлдвэрийн хөгжил болон аж үйлдвэрийн эрсдлийн үнэлгээний тайлан
5. Аж үйлдвэрийн бүсийн тогтолцооны төлөвлөлт (аж үйлдвэрийн хөгжил, аж үйлдвэрийн хувирах чадвар)
6. Хөгжлийн бүсэд үйлдвэрлэлийн зориулалттай барилгын байгууламжийн төлөвлөлт
7. Хөгжлийн бүсийн аж үйлдвэрийн бизнес стратегийн төлөвлөлтөнд мэдээлэл, технологийн шинэчлэл
8. Аж үйлдвэрт хөрөнгө оруулалт хийх төлөвлөлт
9. Хөгжлийн бүсийн нэгдсэн төлөвлөлтийн удирдлагын тогтолцоо
10. Макро эдийн засагт хөгжлийн бүсийн нөлөөлөх үнэлгээний тайлан (жилд нэг удаа)
11. Үйлдвэрлэл болон хотын хөгжлийн уялдаа холбооны стратеги
12. Ажиллах хүчний эрх, ашгийг хамгаалах төлөвлөлт:
13. Тухайн газрын нийгэм, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
14. Хөгжлийн бүсийн дүр төрх болон брэндийн хөгжлийн стратегийн төлөвлөлт

1. Байршил болон чиг үүрэг

* Жин Чяо хөгжлийн бүс нь 1990 онд байгуулагдсан Хятад улсын анхны экспортын бүтээгдэхүүн боловсруулах бүс бөгөөд улсын эдийн засаг, техникийн 54-н бүсийн нэг юм. Пү Дүн дүүрэг нь Шанхай хотын төв хэсэгт орших бөгөөд шинээр хөгжиж буй үйлдвэрлэл үйлчилгээний тэргүүлэх зэргийн бүс юм.

* Төлөвлөгдсөн талбайн хэмжээ 27.38 кв.км, Жин Чяо нь хойд бүс, өмнөд бүс гэж хуваадаг. Хойд бүс нь 19.94 кв.км, өмнөд бүс нь 7.44 кв.км талбайтай. Одоогийн байдлаар уг хөгжлийн бүсэд ойролцоогоор 2.5 кв.км газар нь ашиглагдаагүй сул байна.



- - **Бүсийн газар ашиглалтын хэмжээ** : Жин Чяо бүс нь дунджаар 1 км.кв газарт 163 сая юанийн хөрөнгө оруулалт хийгдсэн бөгөөд уг бүсийн 57.9 хувьд нь бүтээн байгуулалт хийгдсэн. Бусад хөгжлийн бүсүүд нь дунджаар 1 кв.км газарт 58 сая юанийн хөрөнгө оруулалт хийгдсэн байдаг бөгөөд үүнээс харахад Жин Чяо хот нь бусад хөгжлийн бүсүүдээс 3 дахин их хөрөнгө оруулалт хийгдсэн байна.
- **Амьдрахад таатай, тэргүүлэх зэргийн экологийн орчин бүхий эко аж үйлдвэрийн бүс юм.** Бо Юн хороолол, аж үйлдвэрлэлийн хотын хөгжлийн үзэл баримтлал нь .
- Дэвшилтэт,
- Эв нэгдэлтэй амьдрах,
- Эко-аж үйлдвэрийн парк
- Экологийн орчин бүхий үйлдвэрлэл.
- Рik хүрээлэл,

4. Төсөл сонгон шалгаруулсан байдал

2010 оны эцсийн байдлаар 1028 төслийг сонгон шалгаруулсан бөгөөд нийт оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 17626 сая ам.доллар, үүнээс гадаадын хөрөнгө оруулалт 6943 сая ам.доллар байна.


Жин Чяо хөгжлийн бүс нь 2009 онд шинээр нийтдээ 50 төсөл сонгон шалгаруулсан бөгөөд үүний улмаас санхүүжилт нь нэмэгдсэн сонгон шалгаруулсан 35 төсөл нь гадаадын хөрөнгө оруулалт ба нийт хэмжээ 478 сая ам.доллар, 373 сая ам.долларын гадаадын хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан, дотоодын хөрөнгө оруулалт 1.32 тэрбум юань болсон.

Үндэстэн дамнасан корпораци	2010 оны байдлаар «Баялаг» сэтгүүлд мэдээлснээр, “Дэлхийн 500 шилдэг” ААН-н 54 нь Жин Чяо хөгжлийн бүсийн 90 төсөлд хөрөнгө оруулалт хийв.
Томоохон төслүүд	Хөрөнгө оруулалтын хэмжээгээр нь авч үзвэл 30 сая ам.доллараас дээш хөрөнгө оруулалттай 85 төсөл, үүнээс 50 сая ам.доллараас дээш хөрөнгө оруулалттай 52 төсөл, 1 тэрбум ам.доллараас дээш хөрөнгө оруулалттай 21 төсөл, 10 тэрбумаас дээш хөрөнгө оруулалттай 3 төсөл байна.
Дэвшилтэт технологи бүхий ААН	Хөгжлийн бүс д үйл ажиллагаагаа эрхэлж байгаа 100 орчим ААН нь дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн дэвшилтэт технологи ашиглаж байна.

5. Шанхай хотын хөгжилд оруулсан хувь нэмэр

1992 оноос 2010 оны эцэс хүртэл хөгжлийн бүсэд 1.3053 их наяд юаны бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгдсэн бөгөөд, жилийн дундаж өсөлт 43%; бараа бүтээгдэхүүний борлуулалтын орлого 1.6760 их наяд юань, жилийн дундаж өсөлт 30%; үүнээс 90 тэрбум юаны татвар улсад төлсөн нь Пу дун болон Шанхай хотын өөрчлөлт шинэчилэл, эдийн засаг болон нийгмийн хөгжилд чухал хувь нэмэр оруулсан юм.

Жин Чяо хөгжлийн бүсийн 1992 оноос 2009 он хүртэлх үйлдвэрлэл, бараа бүтээгдэхүүн борлуулалтын схем



1. Стратеги төлөвлөлт

Стратеги - Жин Чяо экспортын бүтээгдэхүүн боловсруулах бүсийн хөгжлийн стратеги

макро түвшинд хөгжлийн бүсийн өнөөгийн байдал, зорилт, зохион байгуулалт, стратегийг шийдвэрлэнэ.

Гурван төлөвлөлт

Үйл ажиллагаагаа доорхи хэлбэрээр төлөвлөж зохицуулдаг.

• **Хөгжлийн нэгдсэн төлөвлөлт** - Гол төлөв бүсэд орон зайн тохижуулалтанд төлөвлөлт хийх үүнд : бүсийн үйл ажиллагаа, тээвэр, экологи, дэд бүтэц, орон зайн хэлбэрийг тодорхойлно.

• **Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт** - Хөгжлийн бүсийн аж үйлдвэрийн байрлал, эдийн засгийн зорилго, зураг төсөл боловсруулах төлөвлөлт хийнэ.

• **Нийгмийн хөгжлийн төлөвлөлт** - Хөгжлийн бүсэд оршин суух, боловсрол, эрүүл мэнд, амьдрах орчин, амралт, чөлөөт цаг гэх мэт нийгмийн асуудлаар төлөвлөлт хийнэ.

2. Дэд бүтцийн төлөвлөлт

Жин Чяо хөгжлийн бүс 1995 оноос хойш 40 тэрбумын ам.долларын өртөгтэй дэд бүтцийн 9 төрлийн томоохон ажил хийсэн бөгөөд үүнд : зам, цахилгаан, ус, (усан хангамж, ус зайлуулах, бохир ус зайлуулах), нүүрсний хий, холбоо харилцаа, дулаан, VSAT харилцаа холбоо болон талбайн тэгшилгээ зэргийг хийсэн ба цаашид дэвшилтэт шинэ технологи бүхий орчин үеийн үйлдвэрлэлийг татан оруулах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.

Зам— Бүсэд одоогийн байдлаар 20-50метр өргөнтэй талбай , ойролцоогоор 100км урттай зам баригдсан ;

Цахилгаан хангамж - 480000 KVA-ын цахилгаанаар хангах хүчин чадалтай 10 цахилгааны дэд станц :

Борооны ус зайлуулах—88.4м³/сек-ийн хүчин чадалтай борооны ус зайлуулах 5 станц

Бохир ус зайлуулах—100,000 тонн/өдөр хүчин чадалтай бохир шахан зайлуулах 3 станц

Цэвэр ус —300,000 тонн/ өдөр усыг 147KPa даралтаар шахах хүчин чадалтай усан хангамжийн шугам сүлжээ

Байгалийн хий—240,000 куб метр/өдөр хийг 4Kg/cm² даралтаар дамжуулах хүчин чадалтай хийн хоолой


Шуудан, холбоо харилцаа — харилцааны холбооны газар, телефон станц тус бүр нэг ; Шуудангийн газар, шуудангийн салбар тус тус нэг ;

Хиймэл дагуулын холбоо харилцаа - Сансрын холбооны сүлжээний станц (VSAT) хиймэл дагуулын холбооны үйлчилгээ;

Төвлөрсөн дулааны систем - 305 тонн/цаг хүчин чадалтай дулааны 3 цахилгаан станц, 35 км урт дулааны шугам сүлжээг тус тус барьсан.

4. Зохистой харьцаа бүхий аж үйлдвэрийн тогтолцоо

20 жилийн бүтээн байгуулалтын үр дүнд Жин Чяо нь цахим мэдээлэл, автомашин болон автомашины эд анги, орчин үеийн гэр ахуйн цахилгаан бараа, био-анагаах ухааны болон хүнсний бүтээгдэхүүний 4 том салбар аж үйлдвэрийн төв болжээ. 2010 онд нийтдээ 151891 сая юаны бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бөгөөд энэ нь хөгжлийн бүсийн нийт бүтээгдэхүүний 90.8%-г эзэлж байна.



5. Одоо байгаа түвшингөөс илүү өндөр технологи бүхий аж үйлдвэрийн бий болгох.

Одоогоор хөгжлийн бүсийн судлаачдын тоо 16300-д хүрсэн байгаа нь бүсэд ажил эрхэлж буй нийт хүмүүсийн ойролцоогоор 15%-г эзэлнэ. Хөгжлийн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа ААН-дүүд 1000 гаран шинэ бүтээл гаргаж түүндээ патент авсан. ШУ, технологийн үйл ажиллагааны зардлын нийт дүн 6,765 тэрбум юань, үүний 5,245 тэрбум юань нь R&D судалгаа, шинжилгээний зардал байна.

2010 онд, хөгжлийн бүсийн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ 96698 сая юань, өмнөх оны мөн үеийхээс 25.3%-иар өссөн, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд эзлэх хувь 57.8%. Өндөр шинэ технологи бүхий ААН-н үйлдвэрлэлийн хэмжээ 69426 юань, аж үйлдвэрт эзлэх нийт үйлдвэрлэлийн хэмжээ 41.5%.

2010 онд 96,698 тэрбум юаны шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 25.3% -иар өссөн байна. Энэ нь нийт аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үнэ эзлэх хувь 57.8% эзэлж байна.



6. Гол Аж ахуйн нэгжүүд

2010 оны байдлаар, хөгжлийн бүсэд 1 тэрбум юаниас дээш бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн 109 аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнээс 5 тэрбум юаниас дээш 41 аж ахуйн нэгж, 10 тэрбум юаниас дээш бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн 24 аж ахуйн нэгж, 20 тэрбум юаниас дээш бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн 12 аж ахуйн нэгж, 50 тэрбум юаниас дээш бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн 5 аж ахуйн нэгж, 100 тэрбум юаниас дээш бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн 3 аж ахуйн нэгж байна.



7. Аж үйлдвэрийн бүтцийн зохицуулалт, төлөвлөлт

Уламжлалт үйлдвэрлэлийн хэлбэрээр “цэцэглэн хөгжих” нь цаашдаа боломжгүй бөгөөд, аж үйлдвэрийн бүтцийн шинэчилэл хийх зайлшгүй шаардлагатай.

Үйлдвэрлэлийн салбарыг гол болгон үйлдвэрлэл болон үйлчилгээний салбар гэсэн хоёр салаа замаар хөгжүүлэх шинэ зохицуулалтыг хийсэн.

Жин Чяо-д үйлдвэрлэл эрхлэдэг 350 гаруй ААН байдаг ба үүнээс 5 сая юаниас дээш орлоготой 100 гаруй ААН байдаг. Тэдгээрийн жилийн орлого нь 300 тэрбум юань давдаг. Эдийн засаг, судалгаа хөгжил, зураг төсөл, бизнес худалдаа эрхлэлт, үйлчилгээ, гадаад аутсорсинг гэсэн 4 том хэсгээс бүрддэг.

2005-2010 онд хөгжлийн бүсэд шинээр нийт 255 төслийг сонгон шалгаруулсан. Үүнээс үйлдвэрлэлийн салбар 172 буюу 67%-г эзэлж байна. Шинээр сонгон шалгаруулсан төслийн хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 1.24 сая ам.доллар, үүнээс үйлдвэрлэлийн салбарын хөрөнгө оруулалтын хэмжээ 0.91 сая ам.доллар буюу 73%-г эзэлнэ.

1. Би Юн олон улсын хороолол

Би Юн олон улсын хороололын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан талбайн нийт хэмжээ нь ойролцоогоор 4 хавтгай дөрвөлжин км, талбайтай бөгөөд үүнээс ашиглаж болох талбайн хэмжээ 2.4 хавтгай дөрвөлжин км. 25000м² хэмжээтэй тансаг зэрэглэлийн хаус, орон сууц баригдсан бөгөөд худалдаа үйлчилгээ, сургууль, амралт чөлөөт цагаа өнгөрөөх ойролцоогоор 13000м² хэмжээтэй барилга байгууламжийг бас барьсан. Мөн өндөр чанар бүхий эмнэлэг, боловсролын байгууллагыг оруулж ирсэн бөгөөд орчин үеийн тэргүүлэх, дээд зэрэглэлийн стандартад нийцсэн олон улсын хороолол юм.



Би Юн олон улсын хороололд 60 гаруй улсаас ирсэн 1500 гаруй гадны оршин суугчидтай бөгөөд Хятадын Шанхай хотын гадаад орчин суугчдын 90 орчим хувийг эзэлдэг олон улсын соёлыг багтаасан, гадаад хүн амьдрахад хамгийн тохиромжтой олон улсын хороолалуудын нэг юм.

1. Хөгжлийн эргэлт

Жин Чяо хөгжлийн бүс нь 1992 - 1993 оны хооронд “Төлөвлөвлөлт, Барилга бүтээн байгуулалт, Хөрөнгө оруулалт татах” гэсэн “хөгжлийн эргэлтийг” хийсэний үр дүнд газар нутгийг бүхэлд эдийн засгийн эргэлтэнд оруулж, хөрөнгө оруулалт татах ажлыг амжилттай сайн хийж чадсан байна.



2. Санхүүжилтын горим

Газар болон санхүүжилтыг хооронд нь уялдуулах

Хятадын болон, Гадаадын хамтарсан хөрөнгө оруулалт

Хөрөнгийн зах зээл дээрээс хөрөнгө босгох

Санхүүжилтын горим

3. Байгууллагын тогтолцоо

Өмнө нь ЗГ-аас олгосон эрхийн дагуу Жин Чяо хөгжлийн бүсэд ААН-үүдийг үйл ажиллагааных нь хэлбэрээр газар ашиглах, дэд бүтэц хөгжлүүлэх, хөрөнгө оруулалт татах, салбарыг хөгжүүлэх, чадамжийг дээшлүүлэх зэргээр ангилан үйл ажиллагаа явуулж байв.

Жин Чяо хөгжлийн компани нь 1990 оны 09 сард байгуулагдсан ба 1997 оны 12 сард нэрээ Шанхайн Жин Чяо (групп)ХК болгон өөрчилсөн юм. Жин Чяо хөгжлийн бүсийн бүтээн байгуулалтыг хариуцан ажиллаж буй дээд зэргийн төрийн өмчит компани юм.



Жин Чяо хөгжлийн бүсийн удирдлагын хороо 2004 оны 09 сард байгуулагдсан ба ЗГ-аас олгосон эрхийн дагуу Фүдун шинэ хөгжлийн бүсийн төслийн төлөвлөгөө боловсруулж үйл ажиллагааг нь зохицуулах ажил эрхлэдэг.



4.Зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх удирдлага

Зах зээлийн эдийн засгийг
хөгжүүлэх 3 үе шат

1992-1996 он Газар түрээслэх, газар эзэмшүүлэх

1997-2004он Газар болон үйлдвэрийн барилгыг түрээслүүлэх

2005 оноос одоог хүртэл- Судалгаа, хөгжлийн байгууллага, Аж үйлдвэр,
газар түрээслэх

Хөгжлийн бүсийн аж үйлдвэрийн хөгжлийн анализ дүгнэлт (нэг)

- ❖ Хөрөнгө оруулалтыг хэвтээ хувиарлалтаас босоо хувиарлалтруу шилжүүлж, хөрөнгө оруулалт татах (Жишээ нь : Чонгчин хэлбэр)
- ❖ 1. Уламжлалт хэлбэрийн боловсруулах үйлдвэрийг өөрчлөнө.
- 2. Тухайн орон нутгийн нөхцөлд таарсан хөрөнгө оруулалтыг тататж ажлын байраар хангах.
- 3. Нийлүүлэлтийн хэлхээ холбоог орон нутгийн хөгжлийн үндэс суурь болгох.
- 4. Судалгааны төвийг бий болгож байж томоохон үйлдвэрлэлийг бий болгоно.
- 5. гадаад валют бий болгох



Хөгжлийн бүсийн аж үйлдвэрийн хөгжлийн анализ дүгнэлт (хоёр)

- ❖ Аж үйлдвэрийн шилжилтийг дагаж удирдлагын тогтолцоог сайжруулан дунд хугацааны хөгжлийн бодлогийг бий болгосон нь баруун бүс нутагт үсрэнгүй хөгжил авчрсан юм. (Жишээ нь : Чонг чин хөгжлийн бүсийн үүлэн тооцоолуур үйлдвэр бизнесийн үйл ажиллагааг сайжруулдаг шинэ төрлийн ухаалаг IT)
- ❖ Дүгнэлт нэг : Салбарын удирдлагын тогтолцоог чухалчлан судалж төрийн захиргааны төв байгууллагатай хамтарч ажиллах нь амжилтанд хүрэх явдал юм. Мэтгэлцэх, зөвшилцөх хэлбэрээр давуу талаа ашиглах нь хүнд байдлаас гарах арга зам юм. Үүнд тухайн нутгийн аж үйлдвэрийн хэлхээ холбоо их хамааралтай. Дээрхийг нэгтгэн үзвэл: Зах зээл нь хаалттай ба нээлттэй, дээд доод зэрэглэлтэй бх бөгөөд үүнийг хянаж байх ёстой юм.
- ❖ Дүгнэлт хоёр : Дан ганц байгалын баялагаар зогсохгүй. Байгалийн баялагийг баяжуулан боловсруулах хэрэгтэй.

Хөгжлийн бүсэд хөрөнгө оруулалт татах ТӨЛӨВЛӨГӨӨ

❖ **Хөгжлийн бүсэд шинэ нөхцөл байдлаар хөрөнгө оруулалт татах зарчмын**

1. Хөрөнгө оруулалт татах зарчим бий болгох
2. Хөрөнгө оруулалт татах дүр төрхийн зөвлөмж
3. Хөрөнгө оруулалт татах бүтээгдэхүүн төрлийн загвар зохион бүтээх
4. Хөрөнгө оруулалт татах урьдчилсан төсөл хөтөлбөр боловсруулах
5. Хөрөнгө оруулалт татах хүний нөөцийг бэлтгэх
6. Хөрөнгө оруулалт татах онолын инноваци
7. Хөрөнгө оруулалт татах тактик арга
8. Хөрөнгө оруулалт татах оюунаараа хөрөнгө босгох

